

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-9
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-20
	1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	10-20

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 16-ны өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 29 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Д.Цогтбаатар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Энх-Амгалан.

**Нэг.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор О.Мөнхбаатар, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга, Монголбанкны Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Б.Гантуяа, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монголын хуульчдийн холбооны гишүүн, хуульч Б.Батзориг, Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга Б.Баатарсайхан, Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Д.Батсүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан

хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр 39.10-т заасны дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

**Нэг.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

*Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Мөнхбаатар:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8 дахь хэсгийн “Гэмт хэрэг үйлдсэн этгээд түүнийг яллагдагчаар татахаас өмнө” гэснийг “Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 9 дэх хэсгийн “дууссан эсэхээс” гэснийг “дууссанаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийг 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4

Бүгд: 12  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 1, 2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дахь хэсгийг хасах.

“1.Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс ажлын чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар зүйлийн “5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тэнцүү байна” гэсний дараа “Энэ хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэрэгт оногдуулах торгох ялын нэг нэгж нь хоёр мянган төгрөгтэй тэнцүү байна” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 2 дугаар зүйлийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “найман жил” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар” гэснийг “хүртэл хугацаагаар” гэснийг “хүртэл, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 2 дугаар зүйлийн 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “энх тайвны эсрэг” гэсний дараа “, авлигын” гэж гэснийг “энх тайвны эсрэг гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй.” гэсний дараа “Авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн 3 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 3 дахь хэсгийн “улс төрд нөлөө бүхий этгээд” гэсний дараа “, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “1 дэх хэсэг:” гэснийг “1 дэх хэсэг, 1.1, 1.2 дахь заалт:” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 1, 2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдснаар өөрчлөн найруулах.

“1.Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 1 дэх хэсгийн “хууль ёсны болох нь” гэснийг “үндэслэлгүй болох нь” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай Тайлбар нэмэх:

“Тайлбар.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 4 дүгээр зүйлийн “22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтын “томилогдох” гэснийг “ажиллах” гэснийг “22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтын “сонгогдох” гэснийг “ажиллах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 7  
Бүгд: 11

66.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 4 дүгээр зүйлийн “22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтын “гурван жил” гэснийг “хоёр жилээс таван жил” гэж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

#### **Найруулгын санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын “3.1.4-т” гэсний өмнө “3 дугаар зүйлийн” гэж, мөн зүйлийн “4.1-д” гэсний өмнө “4 дүгээр зүйлийн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13  
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13  
76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

#### **Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй санал томьёолол:**

#### **Нэг.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

**Л.Мөнхбаатар:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Авлигатай тэмцэх газар” гэснийг “Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хоёр.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

**Л.Мөнхбаатар:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Авлигатай тэмцэх газар” гэснийг “Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Гурав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

**Л.Мөнхбаатар:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8 дахь хэсгийн “Хорин хоёрдугаар бүлэгт заасан” гэснийг “Хорин хоёрдугаар бүлгийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “, 32.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5 дахь заалт, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтын “гэмт хэргийг” гэсний өмнө” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 1 дэх хэсгийн “хууль ёсны болох нь тогтоогдоогүй” гэснийг “үндэслэлгүй болох нь тогтоогдсон” гэж өөрчлөх найруулгын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13

84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр 39.10-т заасны дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт орох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.



Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр 39.10-т заасны дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр 39.10-т заасны дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 17 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 35 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 04 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Л.МӨНХБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР  
/БААСАН ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Л.Мөнхбаатар ирсэн, Н.Алтанхуяг гишүүн хүрэлцэн ирсэн, Ш.Адъяаа гишүүн хүрэлцэн ирсэн, С.Бямбацогт гишүүн ирсэн, Б.Дэлгэрсайхан гишүүн орон нутаг ажилтай, Ц.Мөнх-Оргил гишүүн ирсэн, Ц.Мөнхцэцэг гишүүн ирсэн, Х.Нямбаатар гишүүн ирсэн, Ш.Раднаасэд гишүүн ирсэн, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, Ж.Сүхбаатар гишүүн ирсэн, Н.Учрал гишүүн ирсэн, Б.Энхбаяр гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Ингээд Байнгын хорооны хуралдааны гишүүдийн ирц бүрдсэн байна. Ингээд Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг асуудал хэлэлцэнэ. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Засгийн газар 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрөө мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч миний бие хийнэ.

Ажлын хэсгийн гишүүд байрлалаа эзлээрэй. Ш.Адъяаа гишүүн хүрэлцэн ирсэн. Тэмдэглүүлье.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт эргэн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор байгуулж, миний бие ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр нар орж ажилласан болно.

Түүнчлэн ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй ажлын хэсэгт Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын Хуульчдын холбоо, Монголын эмгөөлөгчдийн холбоо болон эрдэмтэн, судлаач нар орж ажиллалаа.

Ажлын хэсгээс авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байх, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд болон төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн удирдах эрх бүхий албан тушаалтан үлдсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж, 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийдэхээс гадна хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэхгүй байх, Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар шалгах зэрэг зарчмын зөрүүтэй саналыг гаргасан болно.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүгдээс хүсье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх Максимын Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монголбанкны Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Б.Гантуяа, Улсын ерөнхий прокурорын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурдаа С.Гантулга, Хууль зүйн

үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монголын хуульчдийн холбооны гишүүн, хуульч, доктор, дэд профессор Б.Батзориг, Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга Б.Баатарсайхан, Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч Д.Батсүх нар оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 5 саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8 дахь хэсгийн “Гэмт хэрэг үйлдсэн этгээд түүнийг яллагдагчаар татахаас өмнө” гэснийг “Сэжигтэн мөрдөн шалгах ажиллагаанаас” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 9 дэх хэсгийн “дууссан эсэхээс” гэснийг “дууссанаас” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

3.Төслийн 1 дүгээр зүйлийг 2 дахь заалтыг хасах. Санал хураалт. /алх цохив/

Хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь уг саналыг дэмжсэн байна.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг хасах. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 1, 2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дахь хэсгийг хасах.

“1.Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс ажлын чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл

хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

6.Төслийн 2 дугаар зүйлийн “5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тэнцүү байна” гэсний дараа “Энэ хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэрэгт оногдуулах торгох ялын нэг нэгж нь хоёр мянган төгрөгтэй тэнцүү байна” гэснийг хасах. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

7.Төслийн 2 дугаар зүйлийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “найман жил” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар” гэснийг “хүртэл хугацаагаар” гэснийг “хүртэл, эсхүл энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

8.Төслийн 2 дугаар зүйлийн 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “энх тайвны эсрэг” гэсний дараа “, авлигын” гэж гэснийг “энх тайвны эсрэг гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй.” гэсний дараа “Авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй.” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

9.Ажлын хэсгийн 3 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 3 дахь хэсгийн “улс төрд нөлөө бүхий этгээд” гэсний дараа “, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан” гэж нэмэх. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “1 дэх хэсэг:” гэснийг “1 дэх хэсэг, 1.1, 1.2 дахь заалт:” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 1, 2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдснаар өөрчлөн найруулах.

“1.Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй

үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” Санал хураалт. /алх цохив/

Хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь уг саналыг дэмжсэн байна.

12.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 1 дэх хэсгийн “хууль ёсны болох нь” гэснийг “үндэслэлгүй болох нь” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай Тайлбар нэмэх:

“Тайлбар.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.” Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 63.6 хувь нь дэмжлээ.

13.Төслийн 4 дүгээр зүйлийн “22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтын “томилогдох” гэснийг “ажиллах” гэснийг “22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтын “сонгогдох” гэснийг “ажиллах” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Техник ажилласангүй юу. Ц.Мөнхцэцэг гишүүн горимын санал гаргая.

**Ц.Мөнхцэцэг:** Сая санал хураах төхөөрөмж маань гацсан учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Ц.Мөнхцэцэг гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 58.3 хувь нь дэмжсэн байна.

Одоо үндсэн санал хураалтыг явуулъя. Түрүүн томьёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн байна.

14.Төслийн 4 дүгээр зүйлийн “22.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтын “гурван жил” гэснийг “хоёр жилээс таван жил” гэж” гэснийг хасах. Санал хураалт. /алх цохив/

Уг санал хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувиар дэмжигдсэн байна.

Найруулгын санал.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын “3.1.4-т” гэсний өмнө “3 дугаар зүйлийн” гэж, мөн зүйлийн “4.1-д” гэсний өмнө “4 дүгээр зүйлийн” гэж тус тус нэмэх.

Энэ санал хураалтын дараа хэлчих үү. Найруулга аа хэлчих. Тийм ээ. Санал хураалт. /алх цохив/

Хуралдаанд оролцсон гишүүдийн 61.5 хувь нь уг саналыг дэмжсэн байна.

**Ц.Мөнх-Оргил** гишүүн дараагийн санал хураалтын өмнө найруулгын санал хэлье.

**Ц.Мөнх-Оргил:** Сая санал хураасан 12 дугаар санал хураалт дээр найруулгын засвар оруулахгүй бол. Нөгөө хууль ёсны болох нь гэдгийг үндэслэлгүйгээр болох нь гээд өөрчлөхөөр нөгөө тогтоогдоогүй бол гэж үг нь үлдчихээд байна.

Тэгэхээр “хууль ёсны болох нь тогтоогдоогүй бол” гэдгийг “үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол” өөрчлөх хэрэгтэй юм байна.

Тэгээд та найруулгаар засаад авчих уу.

**Л.Мөнхбаатар:** Найруулгаар тогтоогдсон бол гэдэг үгийг нэмээд найруулгаар уг саналыг авчихъя. Тийм ээ. Санал хураах шаардлагатай юу.

**Ц.Мөнх-Оргил:** Хураачихъя хураачихъя.

**Л.Мөнхбаатар:** Хураалгаад баталгаажуулчихъя. Тийм ээ. Найруулгаар.

Тэгвэл зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэх. Түүгээр санал хураа. Дараагийн санал хураалтдаа явж байя. Уг саналын томъёоллыг бэлтгэх хүртэл.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, ишлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь дэмжсэн байна.

Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй санал томъёолол.

Нэг.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Авлигатай тэмцэх газар” гэснийг “Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Уг санал хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь дэмжсэн байна.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. /алх цохив/

Уг санал хуралдаанд оролцсон гишүүдийн 69.2 хувь нь дэмжсэн байна.

Хоёр.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Авлигатай тэмцэх газар” гэснийг “Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь уг саналыг дэмжсэн байна.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. /алх цохив/

Уг асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь дэмжсэн байна.

Гурав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 8 дахь хэсгийн “Хорин хоёрдугаар бүлэгт заасан” гэснийг “Хорин хоёрдугаар бүлгийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь дэмжсэн байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6 дахь хэсгийг хасах. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 76.9 хувь нь дэмжсэн байна.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “, 32.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5 дахь заалт, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтын “гэмт хэргийг” гэсний өмнө” гэснийг хасах. Санал хураалт. /алх цохив/

Уг саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 69.2 хувь нь дэмжсэн байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсгийн санал байхгүй.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.



Хуулийн төслийн ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын санал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Одоо найруулгын нэг санал байгаа. Тийм ээ. Ц.Мөнх-Оргил гишүүн найруулгын саналаа. Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ найруулгын санал юм байна. Яагаад гэвэл бид нар нөгөө агуулгаар “хууль ёсны болох нь” гэдгийг “үндэслэлгүй болох нь” гэдгээр хураачихсан юм чинь.

Тэгэхээр дарга аа, 12-ыг дахиад ингээд хураалгаад өгөөч.

Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 1 дэх хэсгийн “хууль ёсны болох нь тогтоогдоогүй” гэснийг “үндэслэлгүй болох нь тогтоогдсон” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай Тайлбар нэмэх гэдгээр санал хураалгаад өгөөч. Тэгэх юм бол найруулга нь зөв болчхож байна.

Тийм. Шууд хураалгачих.

**Л.Мөнхбаатар:** Ц.Мөнх-Оргил гишүүний томъёолсон найруулгын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/ Гишүүд ээ, санал хураалт.

Уг санал хуралдаанд оролцсон гишүүдийн 84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт орох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууссан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Ш.Раднаасэд гишүүн. Гишүүд сууж байгаарай. Одоо санал хураалттай.

**Ш.Раднаасэд:** Энэ яагаад тэр Авлигатай тэмцэх газар гэдгийг өөрчилчхөж байгаа юм.

Байнгын хорооны санал, дүгнэлт гэж. Байнгын хороо яах юм. Тэр өгсөн материалыг Авлигатай тэмцэх газарт өгөх үү, эндээ хадгалах уу гэдэг санал дүгнэлт гаргах юм уу? Тийм шаардлага байгаа юм уу.

Зүгээр Авлигатай тэмцэх газар нь хадгалуулаад яв л даа. Тэртээ тэргүй олон нийтэд л ил болдог биз дээ. Мэдээлэл чинь. Энд байлгаж юм засах гээд байгаа юм уу. Одоо яах гээд байдаг юм. Үүнийг ямар үндэслэлээр өөрчилж байгаа юм. Энэ дандаа Их Хурлын гишүүд юм шүү дээ.

Засгийн газрын гишүүдийнх тэнд байгаад болоод байна шүү дээ. Тэгээд. Энэ ямар хэрэгтэй юм. Ингэх. Энэ яагаад үүнийг өөрчилж байгаа юм. Би тэрийг нь сонсмоор байна. Нэгдүгээрт.

**Л.Мөнхбаатар:** Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулья.

Энэ Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр Авлигатай тэмцэх газар гэснийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Авлигатай тэмцэх газар гэж өөрчлөх гэсэн ийм өөрчлөлтийг ажлын хэсгийн гишүүд олонхийн саналаар дэмжсэн.

Өмнө нь бол энэ зөвлөл нь Ёс зүйн хороог Ёс зүйн дэд хороо хариуцахаар байсан. Ингээд Ёс зүйн дэд хороо байхгүй болоод Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо байгуулагдсан учраас энэ Байнгын хороонд нь харьяалуулах нь зүйтэй юм байна. Ёс зүйн хороо өөрчлөгдөөд зохион байгуулагдсан учраас гэдэг энэ агуулгаар нь оруулсан.

Улсын Их Хурлын тухай хуулийн 24-ийн хэд билээ. 24.4.5 дээр гишүүний хөрөнгө орлогын мэдүүлэг гэсэн ийм заалт байгаа. Энэ нь Ёс зүйн хороо гэж байсныг нь одоо байхгүй болсон учраас Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо гэдэг үгийг нь оруулаад, тэгээд Авлигатай тэмцэх газар хянадагаараа хянаад явах нь зүйтэй юм байна гэсэн ийм агуулга оруулсан байгаа.

Ш.Раднаасэд гишүүн тодруулья.

**Ш.Раднаасэд:** Та нар юунаасаа айгаад байгаа юм. Хөрөнгө орлогын мэдүүлгээ аваачаад тэнд өгөхөд. Энд байлгаж засах гээд байгаа юм уу. Хэл ам гарвал.

Энэ чинь онлайнаар тэнд чинь оччихож байгаа шүү дээ. Энд та нар байрлаад л орон засдаг шүү дээ. Нэг тоо хасдаг биз дээ. Араас нь. Орон андуурчхаж гээд. Үүнийгээ боль л доо.

Би ярьж дуусаагүй байна. Л.Мөнхбаатар аа байж бай.

Үнэхээр хулгай хийгээгүй юм бол юундаа ингээд орж ирснээр нь Авлигатай тэмцэх газар гээд явуул л даа. Аан. Энэ ямар хэрэгтэй юм бэ. Үүнийг яагаад. Энэ Байнгын хороон дээр юу гэсэн санал, дүгнэлт гаргах юм. Би наадахыг чинь ойлгохгүй байна.

Орж ирсэн хуулийн төсөлтэй холбогдуулан Байнгын хороо санал, дүгнэлт гаргаж байх ёстой. Эсвэл Их Хуралд өргөн барьсан ямар нэгэн асуудал Их Хуралд хэлэлцэх ёстой гэсэн асуудал дээр. Үүнийг хаана хадгалах вэ гэдгийг хэлэлцээд сууж байх ийм ямар хэрэгтэй юм. Энэ цаас.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Би хариулчихъя.

Энэ ямар агуулгатай орсон бэ гэхээр нэгдүгээрт, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд нь энэ Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт орсны дагуу гишүүдийн хөрөнгө орлогын мэдүүлгийн асуудал өөрөө орж байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт, энд таны хэлсэн шиг бас бүгд онлайнаар бөглөж байгаа. Энэ бөглөсөн мэдээллүүд Авлигатай тэмцэх газар шууд очиж байгаа. Үүнийг Улсын Их Хурал болоод Байнгын хорооны зүгээс ямар нэгэн өөрчлөлт оруулах боломжгүй. Авлигатай тэмцэх газар хянадгаараа хянаж байгаа. Гэхдээ гишүүдийн Улсын Их Хурлын тухай хуульд заасныхаа дагуу ерөөсөө Ёс зүйн хороо гэж байсныг нь л одоо Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо гэдэг үгийг нь л нэмсэн юм. Тэгээд Авлигатай тэмцэх газар гэдэг нь хэвээрээ явж байгаа гэдгийг та танилцуулъя.

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Уг хуулийн төслийг хэлэлцэж дууслаа. Зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах хуулийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Одоо ингээд үргэлжлүүлээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд Байнгын хорооны гишүүд, ажлын дэд хэсгийн гишүүд зохих бэлтгэлээ хангаад идэвхтэй оролцохыг хүсье.

БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД